

ЯПОН, ОРОСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА*У.Загдцэсэм**

1991 оны 12 дугаар сарын 27-нд Япон Улс Оросын Холбооны Улсыг ЗХУ-ын албан ёсны өв залгамжлагч гэж хүлээн зөвшөөрснөөс хойш энэ хугацаанд хоёр улсын хооронд нааштай өөрчлөлтүүд гарсаар байна. Орос улс ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжиж, Япон улс олон улсын тавцанд бие даасан, идэвхитэй байр суурь баримталж байгаа нь хоёр орны харилцааны хөгжилд ихээхэн нөлөөлсөн юм.

Япон, Оросын эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаа одоогийн байдлаар зогсонги байгаагийн гол шалтгаан нь газар нутгийн асуудал, Оросын татварын хууль эрх зүйн систем боловсронгуй биш зэрэг хүчин зүйлүүд нөлөөлж байна. Сүүлийн үед Япон, Оросын эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагааг дунд болон урт хугацаанд хөгжүүлэхийн, дээрх саад бэрхшээлүүдийг арилгахын тулд хоёр тал багагүй хүчин чармайлт гаргаж байна. Жишээлбэл, Оросын Алс Дорнодод байрладаг Сахалины Шелефийн нефть болон байгалийн хийг ашиглах үйл ажиллагаанд Японы хувийн компаниудын оролцоо идэвхижиж, тэдгээрийн үйл ажиллагааг хэвийн хангахын тулд Оросын тал ч дотоодын хууль эрх зүйн орчинг өөрчлөн шинэчлэх арга хэмжээ авч эхэллээ. 1994 оны 11 дүгээр сард Япон улсад ОХУ-ын Засгийн газрын Ерөнхий сайдын нэгдүгээр орлогч О.Сосковец айлчилсан юм. Энэ айлчлалын үеэр хоёр улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны Засгийн газар хоорондын комисс байгуулахаар хоёр тал шийдвэрлэсэн билээ. Энэ комиссын Оросын талын даргаар О.Сосковец, Японы талын даргаар Гадаад хэргийн яамны сайд, Ерөнхий сайдын орлогч Кононо Ёохэй нар ажиллах болжээ. Энэ комиссын бүрэлдэхүүнд 3 ажлын хэсэг томилогдож дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилтыг тавьсан юм. Үүнд:

1. Хоёр орны худалдаа, эдийн засгийн харилцаан дахь саад бэрхшээлийг арилгах, хувийн бизнесийн идэвхийг нэмэгдүүлэх
2. Орост үзүүлэх тусламжийн программ боловсруулж хэрэгжүүлэх
3. Япон болон Алс Дорнодын эдийн засгийн харилцааг бэхжүүлэх зэрэг юм.

1996 онд Орос улсад айлчилсан Японы Гадаад хэргийн яамны сайд Икэда Юкихикогийн айлчлалын үеэр Япон, Оросын худалдаа,

* У.Загдцэсэм - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан

эдийн засгийн хамтын ажиллагааны Засгийн газар хоорондын комиссын анхдугаар хуралдаан болжээ. 1997 оны 6 дугаар сарын 9-нд Токиод тус комиссын 2 дахь хуралдаан болж Оросын талаас Ерөнхий сайдын орлогч Борис Немцов, Японы талаас Гадаад хэргийн сайд Икэда Юкихико нар даргалжээ. Энэ хуралдаанаар Орост дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нь чухал гэдгийг хоёр тал онцлон тэмдэглэхийн сацуу мөн хувийн хөрөнгө оруулалт чухлыг тэмдэглэсэн юм. Мөн энэ үеэр Алс Дорнод, Японы хоорондын эдийн засгийн харилцааг хөгжүүлэх талаар хэлэлцжээ.

1998 оны 3 дугаар сарын 24, 25-нд Южно-Сахалинск хотод ажлын хэсгийн хуралдаан болж, энэ үеэр Япон, Оросын Засгийн газрын бус эдийн засгийн хороо ба Оросын Алс Дорнод, өвөр Байгалийн нийгэмлэгийн уулзалт болжээ.

1999 он хүртлэх Япон, Орос /ЗХУ/-ын худалдааны эргэлт

/млрд. иэн/

	Японы экспорт	Японы импорт	Худалдааны нийт эргэлт
1987 он	372,0	340,8	712,8
1988 он	401,5	355,2	756,7
1989 он	423,0	413,3	836,3
1990 он	371,0	482,9	853,9
1991 он	285,0	447,6	732,6
1992 он	136,0	304,7	440,7
1993 он	166,7	307,2	473,9
1994 он	120,2	355,3	475,5
1995 он	108,2	444,8	553,0
1996 он	111,3	428,4	539,7
1997 он	122,7	483,1	605,8
1998 он	127,6	377,7	505,2
1999 он	54,7	428,5	483,2

Эх сурвалж: Японы Сангийн яамны гаалийн статистик¹

1999 оны байдлаар Япон, Оросын худалдааны бүтцийг авч үзвэл Японы талын экспортод машин үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн 14,8%, автомашин 23,4%, цахилгаан бараа 17,7%, химийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн 2,9%, төмөр 10,6%, автомашины дугуйн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн 8,3%, машины сэлбэг 2,2%, бусад 20,1%-ийг эзэлжээ.

Мөн Японы талын импортод өнгөт төмөрлөг 38,7%, далайн бүтээгдэхүүн 31,5%, ой мод 16,4%, нүүрс 4,8%, болд 1,5%, бусад 7,1%-ийг эзэлжээ.

2002 онд Япон, Оросын худалдааны нийт эргэлт 2001 онтой харьцуулбал 5%-иар буурчээ. “РИА Новости”-ийн сурвалжлагчийн Японы Сангийн яамны мэдээг иш татан дурдсанаар хоёр орны худалдааны эргэлт 527 тэрбум иэн буюу 4,4 тэрбум ам.доллар болсон нь 2001 оны үзүүлэлттэй харьцуулахад 29 тэрбум иэнээр бага байна. Үүний шалтгаан нь Японы импорт багассантай холбоотой. Японы талын импорт 2001 онд 468 тэрбум иэн байсан бол 2002 онд 408 тэрбум иэн болж буурчээ. Харин Японоос Орост нийлүүлсэн экспорт 2001 онд 87 тэрбум иэн байсан бол 2002 онд 118 тэрбум иэн болж өссөн нь 980 тэрбум доллартай тэнцэж байна. Цахилгаан бараа, тоног төхөөрөмжийн нийлүүлэлт нэмэгдсэн байна. Жишээлбэл компьютерийн техникийн нийлүүлэлтийн хувь 140%-иар, өнгөт телевизор 144%-иар тус тус нэмэгджээ. 2002 онд Японоос Орост 50848 мянган автомашин гаргасан нь 2001 онтой харьцуулахад 49%-иар нэмэгджээ. Сүүлийн хэдэн жил Орос, Японы автомашин, телевизорын худалдааны эргэлт багассаар байснаа 2002 онд эрс нэмэгджээ.

Гэсэн хэдий ч Орос, Японы худалдааны эргэлтийг Орос, Хятадын худалдааны эргэлтийн үзүүлэлттэй харьцуулан үзэхэд тал хувиас нь ч бага байна. “РИА Новости”-ийн мэдээлснээр Орос, Хятадын худалдааны эргэлт 2002 оны эхний 10 сарын дотор 2000 оны мөн энэ хугацаатай харьцуулбал 18%-иар нэмэгдэж, 9,8 тэрбум долларт хүрсэн байна.²

Японы Гаалийн статистик, Оросын Эдийн засгийн хөгжил худалдааны яамны статистикаас үзэхэд 2003 оны эхний 5 сарын дотор хоёр орны худалдааны эргэлт 2002 онтой харьцуулахад 35%-иар нэмэгдэж /2172 сая долларт хүрч/, экспорт 33%-иар /1627 сая долларт хүрч/, импорт 40%-иар /545 сая доллар/ тус тус өсчээ. Японы талын худалдааны ашиг өмнөх онтой харьцуулахад 29%-иар нэмэгдэж, нийтдээ 1082 сая ам.доллар болжээ.³ Энэ үеэс Японд үйлдвэрлэл, барилгын салбарт Оросын материалыг өргөнөөр хэрэглэдэг болжээ. Орост Японы компаниудын хөрөнгө оруулалт өсч, үйл ажиллагаа нь өргөжсөн явдал дээрх үзүүлэлтэд эерэгээр нөлөөлсөн юм.

Оросын экспортын бүтцийн хувьд эрдсийн түлш 2.9%-иар, хар төмөрлөг 20%-иар, загас болон далайн бүтээгдэхүүн 24%-иар тус тус нэмэгджээ.

Оросын импортын бүтцийн хувьд машины үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний /голдуу автомашины/ импорт 2,1 дахин, усжуулалтын тоног төхөөрөмж 52%-иар тус тус, барилгын зарим тоног төхөөрөмжийн импорт нэмэгджээ.

Оросын эдийн засгийн өсөлт хурдасч, хүн амын орлогын эх үүсвэр нэмэгдэж буй нь Японы компаниудын сонирхолыг татаж байна. Японы авто машины тэргүүлэх үйлдвэр Тоёота сүүлийн 3 жилд Оросын зах

зээлд бүтээгдэхүүнээ амжилттай борлуулж зах зээлээ өргөжүүлсээр байна. 2002 онд Тоёота-гийн машины экспортын хэмжээ өмнөх оньхоос 1.9 дахин нэмэгдэж, 8.6 мянган ширхэг автомашин Орос улсад гаргажээ. Тоёота корпорацийн удирдлага ОХУ-д байрлаж буй албан ёсны гэрээт борлуулагчийн газраа 13 байсныг 20 болгон нэмэгдүүлэх шийдвэр гаргаж, 2007 он гэхэд худалдааны эргэлтээ 30 мянган ширхэг автомашинд хүргэхийг зорьж байна.

Сахалин мужийн амбан захирагч Фархутдинов 2000 оны 8 сарын 29-нд Хоккайдо Шинбун сонинд өгсөн ярилцлагандаа: “Орос, Японы эдийн засгийн харилцааг эрчимтэй хөгжүүлэхийн төлөө мөн Сахалиныг Ази Номхон далайн интеграцид идэвхитэй татан оруулахын тулд дараах асуудлуудыг шийдэх хэрэгтэй. Эдгээр асуудлууд нь далайн хууль бус наймаатай тэмцэх, Агнуурын тэнгисийн нөөцийг хууль бусаар үл ашиглахын төлөө хамтран тэмцэх, хамгийн чухал нь энх тайвны гэрээ байгуулах асуудлыг 4 арлын асуудлаас салгаж шийдвэрлэх нь чухал”⁴ хэмээн онцлон тэмдэглэжээ

“Глобалчлалын үеийн Ази Номхон далайн бүсийн Орос, Японы хамтын ажиллагааны хэтийн төлөв: Хоёр орны харилцааг цаашид хөгжүүлэх нь” сэдэвт Орос, Японы хамтарсан чуулга уулзалт 2003 оны 9 дүгээр сарын 12-13-нд Эрхүүд болж өнгөрчээ. Энэ чуулга уулзалтыг Оросын Стратегийн судалгааны төв, Японы Үндэсний иж бүрэн судалгааны төв хамтран зохион байгуулжээ. Чуулга уулзалтанд хоёр орны нэртэй улс төрчид, эрдэмтэд оролцсоны дотор Оросын Гадаад яамны орлогч сайд А.П.Лосюков, Японы Засгийн газрын төлөөлөгч Т.Арима нар оролцсон байна. Орос, Японы тус чуулга уулзалт нь хоёр орны удирдагчдын болон гадаад хэргийн сайд нарын тохиролцсоны үндсэн дээр зохион байгуулагддаг уламжлалтай. Чуулга уулзалтын гол зорилго нь хоёр орны ард түмний хооронд харилцан ойлголцлыг гүнзгийрүүлэх, мөн хоёр орны дэвшилт хөгжлийг бүх салбарт ахиулах, хоёр талын энх тайвны гэрээг байгуулахад оршдог бөгөөд тус чуулга уулзалтын чухлыг Оросын Ерөнхийлөгч Б.Путин, Японы Ерөнхий сайд Ж.Койзүми нар онцлон тэмдэглэжээ. Уг чуулга уулзалтын баримт бичигт Орос, Японы хамтын ажиллагаа тухайлан шинжлэх ухаан, судалгааны байгууллагуудын хамтарсан чуулга, семинар болон бусад хурал зөвлөлгөөн, арга хэмжээнүүдийг дэмжих ялангуяа Орос, Японы 3 дахь чуулга уулзалтыг зохион байгуулахад онцгой анхаарах нь чухал хэмээжээ.

Энэ чуулга уулзалтын анхных нь 2001 оны 5 дугаар сард “Глобалчлалын үеийн Ази Номхон далайн бүс нутаг дахь Орос, Японы харилцаа” сэдвээр Москвад болсон бөгөөд хоёрдахь нь 2002 оны 5 дугаар сард Санкт Петербургэд чуулж байжээ. Эдгээр чуулга уулзалтуудын үеэр хоёр орны эрдэмтэд хоёр орны харилцааг хөгжүүлэх арга замын талаар

чөлөөтэй ярилцан цаашид олон улсын тавцанд Москва Токиогийн харилцааг бэхжүүлэх, эдийн засаг, соёлын болон бусад салбарт идэвхтэй хамтран ажиллах талаар дэлгэрэнгүй ярилцаж санал солилцжээ. Мөн терроризмтай тэмцэх, хар тамхины хууль бус наймаа, мафитай тэмцэх, байгаль орчныг хамгаалах талаар сонирхолтой ярилцлага болжээ. Хоёр талын соёлын хамтын ажиллагааг хөгжүүлэх асуудлыг тусад нь авч үзжээ.

Эхний хуралдаанаар хоёр талын эдийн засгийн хамтын ажиллагааны асуудлуудыг хэлэлцэж, “Орос, Японы хамтын ажиллагааны төлөвлөгөөнд хоёр талын эдийн засгийн хамтын ажиллагаа нь тэргүүлэх чиглэл байх ёстой” гэж заав. Түүнчлэн сүүлийн үед хоёр талын эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжиж байгаад сэтгэл ханамжтай буйгаа илэрхийлжээ. Тус чуулга уулзалтад оролцогчид Оросын Алс Дорнод болон Японы хамтын ажиллагааны хөгжих хандлагыг сайшаажээ. Үүнд: 2003 оны 1 дүгээр сард Японы Ерөнхий сайд Ж.Койзүми Хабаровскт айлчлал хийсэн, мөн Японы Гадаад хэргийн сайд Ёрико Кавагучи Владивостокт ирэхдээ Орос, Японы Засгийн газар хоорондын комиссын дарга нар ажлын хэсгийнхэнтэй уулзсан уулзалтууд нь хоёр талын хамтын ажиллагаанд эерэг нөлөө үзүүлсэн гэдгийг цохон тэмдэглэжээ. Тус уулзалтад хувийн секторууд оролцсоноор ихээхэн онцлогтой болжээ. Орос, Японы эдийн засгийн хамтын ажиллагаанд ашиглагдаагүй нөөц маш их байгаа. Түүнийг нээн хэрэгжүүлэх нь чухал гэж үзжээ.

Хоёрдахь уулзалтаар эдийн засгийн хөгжилтэй шууд холбоотой глобалчлалын үеийн экологийн ба эрчим хүчний асуудлыг хэлэлцсэн байна. Экологийн асуудлууд глобал чанартай болж буйг онцлон тэмдэглээд байгаль хамгаалах салбарт хамтран ажиллах нь гагцхүү Орос Японы хувьд чухал бус бүс нутгийн хувьд маш чухал гэдгийг дурджээ.

Сибирь Алс Дорнод дахь эрчим хүчний салбарт Орос, Японы хамтын ажиллагааг идэвхижүүлэх нь цаашид Орос болон Ази Номхон далайн бүсийн орнууд юуны өмнө Японтой харилцах харилцааг бэхжүүлж, энэ нь зөвхөн Орос, Японд стратегийн болон геополитекийн ашиг авч ирэхээс гадна мөн ЗХА-ийн тогтвортой хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулах болно. Иймээс чуулга уулзалтад оролцогчид Сахалины нефть болон байгалийн хийн төслийг хэрэгжүүлэх шатанд орох нь чухал гэдгийг тэмдэглэжээ. Мөн Дорнод Сибир, Алс Дорнодоос эрчим хүч авах, Ази Номхон далайн бүс нутгуудад гаргах талаар ярилцсан юм.

Гуравдахь чуулга уулзалт дээр “Орос, Японы эдийн засгийн хамтын ажиллагааны асуудлууд”, “Эрчим хүчний болон экологийн салбар дахь Орос, Японы түншлэл Ази Номхон далайн бүс нутгийн орнуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх гол хүчин зүйл болох нь” гэсэн сэдвүүдээр ярилцжээ. Тус чуулга уулзалт дээр энх тайвны гэрээ байгуулахдаа Шикотан, Хабомай, Иторул, Кунашири арлуудын газар нутгийн асуудлыг шийдвэрлэх нь чухал

бөгөөд стратегийн түншлэлийг бүх чиглэлээр хөгжүүлэх нь зөв хэмээн чуулганд оролцогчид дүгнэжээ.

Энэ гуравдахь хурлын үеэр соёлын асуудлыг өргөн хүрээтэй авч хэлэлцсэн бөгөөд “Японы соёлын фестиваль-2003” болж үүний зохион байгуулалтын талаар өмнөх 2 дахь чуулга уулзалтын үеэр ярилцсан байна. Ийм арга хэмжээ явуулах нь Орос, Японы соёлын түвшинг өндөр хэмжээнд гаргаж хоёр орны ард түмний найрамдал харилцан ойлголцлыг бэхжүүлэх өндөр ач холбогдолтой билээ. Сүүлийн үед Орост Японы зохиолчдын зохиол бүтээлийг орчуулан гаргах нь ихэсч буй нь сайн тал юм гээд нийгмийн бүх салбарт харилцаа холбоог дэмжихийг хоёр тал санал болгожээ. Мөн шинжлэх ухаан, судалгааны байгууллагууд бие биенийхээ судалгааг объектив байр сууринаас хийж үр дүнг хамтран гаргах ёстой хэмээн санал нэгджээ.

Орос, Японы худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг урагшлуулахад ихээхэн хүчин түлхэц болсон үйл явдал бол 2000 оны 9 дүгээр сард ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путины Япон улсад айлчилсан айлчлал юм. Энэ айлчлалын үеэр Оросын тал Япон улстай Орос, Японы эдийн засгийн хамтын ажиллагааны чиглэлээр 15 гэрээ, хэлэлцээрт гарын үсэг зурсан⁵ билээ. Дээрх гэрээ, хэлэлцээрүүд хоёр орны хооронд худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг цаашид бататган хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой эрх зүйн үндсийг бүрдүүлсэн юм. Ерөнхийлөгч В.Путины айлчлалын үеэр Японы тал Орос улсыг олон улсын худалдааны байгууллагад гишүүнээр элсэх, АСЕАН-ы орнуудын эгнээнд нэгдэн ороход тус тус дэмжинэ гэж мэдэгдсэн юм.⁶ Орос улс ч Япон улсыг НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүн орон болоход нь дэмжиж ажиллахаа мэдэгдсэн билээ. Хоёр улсын хооронд газар нутгийн маргаантай асуудал оршсоор байгаа хэдий ч хоёр тал энэ асуудал шийдэгдэхэд цаг хугацаа хэрэгтэй хэмээн үзэж, Япон, Оросын харилцаа хамтын ажиллагаа хэвийн, тогтвортой хөгжинө гэдэгт найдаж байна.

Ашигласан материал

1. <http://www.embjapan.ru/jrr/econotnoshen.html>
2. http://www.vch.ru/cgi-bin/guide.cgi?table_code=13&action=show&id=2695
3. http://www.economy.gov.ru/MertRuntimeWeb/economy/www.economy.gov.ru/merit/13_0.htm
4. <http://www.rambler.ru/db/news/msg.html?mid=1261473&s=9>
5. Олон улс судлал сэтгүүл, 2003, №2
6. О.Добринская. “Отношения Японии с крупными державами АТР”, Мировая экономика и международные отношения, №3, 2003